



ÀÐÕÀÍ ÃÀÉ ÀÉÌ ÃÈÉÍ
ÑÒÀÒÈÑÒÈÈÈÉÍ ÕÝÈÕÝÑ

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2017/08






ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 101 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 209,6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 83,7 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 13,5 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Оны эхний 8 сард 1281 эхээс 1291 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 1,6 хувиар буюу 21 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 289 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 38 тохиолдлоор буюу 11,6 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 13,8, нас баралт 3,1 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 10,7 промил байна. Оны эхний 8 сард эхийн эндэгдэл гараагүй, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн

эндэгдэл 6 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 25,0 хувиар бага байна.

Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 24 гарч мянган амьд төрөлтөд 18,6 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 3 тохиолдлоор буурсан байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 36 нь буюу 334 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(68), Ихтамир (79), Эрдэнэмандал (54), Жаргалант (39) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 17,4 хувь нь салхин цэцгээр, 1,8 хувь нь улаан бурханаар, 41,3 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 12,0 хувь нь сүрьеэгээр, 27,5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 3,9 дахин буюу 972 тохиолдлоор буурсан байна.




АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

9 дүгээр сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 993 ажилгүй хүн байгаагийн 51,5 хувь нь буюу 511 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 178 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2,5 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,8 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 220 нь дээд, 65 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 646 нь бүрэн болон бүрэн бус дунд, 51 нь бага боловсролтой хүмүүс байна.

8 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 409 хүн шинээр бүртгүүлж, 77 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болсон байна. Харин 116 хүн ажилд орсон байна.

Оны эхний 8 сард аймгийн дүнгээр 378 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 104, Эрдэнэмандал, Хангай, Төвшрүүлэх, Цахир, Хотонт, Өгийнуур, Хашаат сумд 20-31 ажлын байрыг, Батцэнгэл, Чулуут, Тариат, Өндөрүлаан, Цэнхэр сумд 11-17 ажлын байрыг, Өлзийт, Булган, Ихтамир, Хайрхан, Жаргалант, Цэцэрлэг сумд 4-8 ажлын байрыг тус тус бий болгожээ.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 8 сард 31,8 тэрбум төг, зарлага 31,1 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 2739,7 сая төг буюу 9,4 хувь, зарлага 2293,8 сая төг буюу 8,0 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 2739,7 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 9,2 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 13,4 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 51,5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.


Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 9,4 хувиар өсөхөд тэтгэвэр, эрүүл мэнд, ажилгүйдлийн даатгалын сангууд өссөн нь нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 26,3 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 983,9 сая төгрөгийг олгосон

нь өмнөх оны мөн үеийнхээс олгосон тэтгэврийн хэмжээ 8,7 хувиар нэмэгдэж харин тэтгэмжийн хэмжээ 0,2 хувиар буурсан байна.

Оны эхний 8 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 20,9 мянган хүнд 7305,1 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 54,2 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 45,8 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 54,1 хувийг халамжийн тэтгэврээр, 29,5 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 16,4 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц






ГЭМТ ХЭРЭГ


Аймгийн хэмжээгээр 253 холбогдогч бүхий 353 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 117, өмчлөх эрхийн эсрэг 175, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 27, байгаль хамгаалах журмын эсрэг 10, бусад 24 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 34 хүн нас барж, 123 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1016,3 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 5,1 хувийг бүлэглэж 21,2 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 616 хүнийг албадан саатуулж 114 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 3,3 хувиар буюу 12 тохиолдлоор буурсаны дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 9,3 хувиар буюу 10 тохиолдлоор өсч харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 13,8 хувиар буурсан байна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2017 оны эхний 8 сард аймгийн төсөвт 13123,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 14658,2 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 111,7 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 5036,0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 6570,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 130.5 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Ихтамир, Хангай, Тариат, Өндөрүлаан, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Батцэнгэл, Цэнхэр, Хотонт, Төвшрүүлэх, Булган, Эрдэнэбулган, Цахир сумд 103,2 хувиас 2.6 дахин биелүүлсэн байна. Харин Чулуут сум 19,0 хувиар тасалсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл бууны татвар, газрын төлбөр, тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж, хөрөнгө худалдсаны орлогоос бусад нэрийн орлогуудыг 100,8 -176,5 хувиар биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 55,2 хувийг тусламжийн орлогоор, 18,5 хувийг орлогын албан татвараар, 1,1 хувийг өмчийн татвараар, 1,9 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 18,1 хувийг бусад албан татвараар, 5.2 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 129,8 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 365,3 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 25.3 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 96,0 сая төгрөг, бүгд 616,4 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 39482,1 сая төгрөг байгаагийн 48,8 хувийг цалин хөлсөнд, 5,4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 45,8 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 38,6 хувийг нийтийн ерөнхий

үйлчилгээнд, 51,4 хувийг боловсролын салбарт, 9.3 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.4 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.2 хувийг бусад салбарт зарцууллаа.

**Орон нутгийн төсвийн байгууллагын
нийт зарлагын бүтэц, хувиар**




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 14,3 тэрбум төгрөгийг авч 21,8 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 8 сард банкууд 41,3 мянган иргэд, аж ахуй нэгжид 89,0 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 61 хүнд 2576,8 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 8 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 27,4 хувиар, олгосон зээлийн хэмжээ 15,4 хувиар өсч харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 36,0 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 22,9 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 8 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.4 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5,6 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 7 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан бараа үйлчилгээний үнэ тарифын 5,1 хувийнх нь өсч, 0,9 хувийнх нь үнэ буурч, 94,0 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас төмс, байцааны үнэ 10,0-16,7 хувиар буурч харин үхэр ямаа адууны мах, ампицillin, эрэгтэй зуны гутал, эрэгтэй хүн, хүүхдийн сорочкон цамц, хивс, ноосон цамц зэргийн үнэ 2,0 – 7,7 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 40,7 хувийнх нь буюу 87 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 1,4 хувийнх нь буюу 3 нэрийн барааны үнэ буурч, 57,9 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс лууван, байцаа, манжингийн үнэ 16,1– 16,7 хувиар буурч, харин тахианы мах,зайрмаг, давс, тамхи, ундаа,цагаан будаа, гурил, алим, элсэн чихэр,өөхөн болон шар тос,ногоон цай, сурагчийн цүнх, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, лаа,трико 4-5 настай охидын, хүүхдийн пүүз,эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, даавуу, гэр ахуйн хэрэгсэл, тавилга, оо, саван,тамхи,хадаас,алим, мандарин зэрэг барааны үнэ 2,9-50,0 хувиар нэмэгдсэн байна.




ХӨДӨӨ АЖ АХУЙ

Одоогийн байдлаар оны эхний хээлтэгч малын 87,3 хувь нь буюу 1866,6 мянган эх мал төллөж, гарсан төлийн 96,0 хувь нь буюу 1792,6 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 96,9 хувь, унаганы 96,5 хувь, тугалын 97,0 хувь, хурганы 96,9 хувь, ишигний 93,9 хувь нь бойжиж байна.

Сумдаас Өгийнуур, Хашаат, Өлзийт, Булган, Цэцэрлэг сумд гарсан төлөө 98,0- 99,7 хувиар бойжуулж байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 15,1 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 13,4 хувиар илүү


байна.



Оны эхний мал 98,0 хувиар онд орж оны эхний малын 2,0 хувь буюу 98,3 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 5,7 хувийг адуу, 10,4 хувийг үхэр, 52,1 хувийг хонь, 31,8 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Эрдэнэбулган, Өндөрүлаан, Жаргалант, Цэцэрлэг, Цэнхэр, Тариат сумдын оны эхний малын 2,0-5,1 хувь нь, бусад сумдын малын 0,2-1,9 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Энэ хавар аймгийн дүнгээр 7710 га-д үр тариа, 479,6 га-д төмс, 171,9 га-д хүнсний ногоо, 1832,7 га-д малын тэжээлийн ургамал, 1400 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд тариалсан үр тариа 51,9 хувиар, төмс 2,4 хувиар, хүнсний ногоо 10,7 хувиар, тэжээлийн ургамал 2,7 дахин, техникийн ургамал 2,2 дахин илүү байна.

9 дүгээр сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр төмс 43.0 тн, хүнсний ногоо 8,2 тонныг хурааж, байгалийн хадлан 8,4 мянган тн, гар тэжээл 41,5 тонныг бэлтгээд байна.

2017 онд манай аймаг ойгоос 100,8 мянган м3 галын түлээ, 12,7 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 113,5 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 8 сард 51,1 мянган м3 галын түлээ, 6,0 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 57,1 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 167,0 сая төгрөг төсвийн орлогод оруулж, ойн зөрчилд 3,6 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 8 сард оны үнээр 3,9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 13,8 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 1301,8 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,1 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 8,9 хувийг хүнс ундааны, 1,1 хувийг хэвлэлийн, 60,8 хувийг дулааны эрчим хүчний, 16,4 хувийг усан хангамж, 4,5 хувийг модон эдлэлийн, 5,4 хувийг гутал хувцасны, 2,9 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлснээр гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, бууз, түгээсэн цэвэр ус дулаан, монгол болон савхин гутал, дээл, хүснэгт маягт, вакуум цонх үйлдвэрлэлт 1,1 – 21,5 хувиар нэмэгдлээ. Харин хэрчсэн гурил, савласан цэвэр ус, зүсмэл, гэрийн модон тавилгын үйлдвэрлэлийн хэмжээ 2,0 – 61,8 хувиар буурсан байна.



2017 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар барилгын байгууллагууд 6432,9 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгээд байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 57,5 хувиар өссөн байна.

Тээврийн байгууллагууд 31,4 мянган зорчигч, 9,3 мянган тонн ачаа тээвэрлэн 14,9 сая хүн км, 2,0 сая ткм ажил гүйцэтгэн 353,3 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа ачаа эргэлт, орлогын хэмжээ 1,1 -93,8 хувиар нэмэгдлээ.

Холбооны байгууллагууд 435 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр

байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 226,6 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3,9 хувиар нэмэгдсэн байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

8 дугаар сард агаарын дундаж температур 11,0-аас 17,6 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Өлзийт, Өгийнуур, Хашаат, Эрдэнэмандал, Жаргалант сумдад 30,0-өөс 32,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Булган, Өндөрүлаан, Хангай, Цахир сумдад –3,0-аас –6,0 хэмд хүрч хүйтэн байсан байна.

8 дугаар сард Эрдэнэбулган, Батцэнгэл, Өндөрүлаан, Цэцэрлэг сумдын нутгаар 132,7 – 168,3 мм тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Жаргалант, Хангай сумдад 28,7- 65,9 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2017.09.11